

**ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ  
АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Зорилт	Төсөв	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хувь
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх		1.1. АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын сайт, мэдээллийн самбарт байршуулж албан хаагчдад сурталчлах	Түгээсэн тоо (Баримтжуулсан байх)	0	20	2024 оны 3 дугаар улирлын байдлаар Авлигатай тэмцэх газрын бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас зэрэг 158 мэдээллийг байгууллагын сайт, фэйсбүүк хаягт хуваалцсан байна. Хуваалцсан мэдээлэл давхардсан тоогоор 2700 гаруй хүний хандалт авсан байна. Байгууллага “Шударга ёс, хөгжил дэвшилд-110” мэдээллийн самбарт сар болгон авлигатай тэмцэх газрын мэдээллийг түгээн ажиллаж байна. Самбарт 12 дугаар сарын байдлаар 12 мэдээллийг байршуулаад байна. <b>Үр дүн:</b> ✓ Байгууллагын фэйсбүүк пейж хуудсаар дамжуулан Авлигатай тэмцэх газрын мэдээ, мэдээллийг тогтмол иргэд, олон нийтэд түгээн ажилладаг болсон. ✓ Авлигатай тэмцэх газрын байршуулсан мэдээллийн хандалтын тоо нэмэгдсэн.	100
				Давтамж (Баримтжуулсан байх)	0	2		
				Авсан хандалтын тоо (Баримтжуулсан байх)	0	500		
			1.2. Авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээг тодорхой сэдвийн хүрээнд зохион байгуулах	Нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан тоо (Үр дүнг тооцож, нотломжийг хавсаргах)	0	2	Хугацаа болоогүй	0

			1.3. Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулах.	Мэдээллийг сар бүр шинэчилж байршуулсан тоо	0	12	Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах, иргэд, олон нийтэд мэдээлэл өгөх зорилгоор “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбарыг ажиллуулж байна. Тус мэдээллийг самбарын мэдээллийг сар бүр шинэчлэн иргэдэд байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны мэдээллийг хүргэн ажиллаж байна. Нийт 12 мэдээллийг байршуулсан. <b>Үр дүн:</b> ✓ Сар бүр шинэлэг цаг үеийн мэдээллийг ил тод самбартаа байршуулдаг болсон.	100
				Тайланд сар бүр шинэчилсэн нотломжийг хавсаргасан байх	0	12		
			1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонины нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэх.	Хоёроос доошгүй сурталчилгааны материал боловсруулсан байх	0	2	Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 3 шторк бэлтгэн байгууллагын албан ёсны сайт, фейсбүүк пейж хуудсанд байршуулан иргэд олон нийтэд түгээж ажиллалаа. Тус бэлтгэсэн материалд Авлигыг мэдээлэх 110 утсыг байршуулан олон нийтэд түгээсэн.	100
				Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудсанд байршуулах /Авлигыг мэдээлэх 110 дугаарыг оруулсан байх/	0	2		
2	Авлигын эсрэг сургалт зохион байгуулах,		2.1.Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг	Шинээр томилогдсон албан хаагчийг	0	1	Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн нь 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр газрын даргын Б/10 тоот тушаалаар томилогдсон. Тус албан	100

	албан хаагчдыг АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах		авлигын эсрэг сургалтад хамруулах	сургалтад хамруулсан тоо			хаагчид “Авлигын тухай ойлголт” сэдвээр байгууллагын газрын дарга С.Хулан нь сургалт зохион байгуулж ажиллалаа. <b>Үр дүн:</b> ✓ Шинээр томилогдсон албан хаагч Авлигын тухай ойлголтой болсон.	
			2.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.	Өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах (Тайланд нотломжийг хавсаргах)	0	2	Хамтран ажилладаг байгууллагуудаа авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сурталчлах зорилгоор “Ирээдүйнхээ төлөө нэгдье” брошюрыг хамтран ажилладаг төрийн байгууллагын албан хаагчдад “110” брошюрыг орон нутгийн өмчит байгууллагуудын өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд түгээж ажиллалаа. <b>Үр дүн:</b> ✓ Байгууллагын авлигын эсрэг хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг хамтран ажилдаг байгууллагуудын албан хаагчид мэддэг болсон. ✓ Хамтын ажиллагаа өргөжсөн	100
3	Авлигын эсрэг үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох		3.1. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт	Байгуулсан бүх гэрээнд авлигаас ангид байх асуудлыг тусгасан эсэх (тийм-1, үгүй-0)	0	1	2024 оны жилийн эцсийн байдлаар Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын Захиралтай байгуулах контракт гэрээ Хоёр дугаар зүйл Орон нутгийн Өмчийн газрын эрх, үүрэг хэсэгт дараах	100

			<p>авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах</p>			<p>Авлигыг мэдээлэх үүргийг тусгасан байх (тийм-1, үгүй-0)</p>	0	1	<p>заалтуудыг тусгасан. Үүнд: 2.10. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх. 2.11. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг журмын дагуу гаргаж, бүртгүүлэх. 2.12. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй үед хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх. 2.13. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй хувь хүн, хуулийн этгээдэд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, түүнийг арилгах талаар бичгээр зөвлөмж өгөх. 2.14. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэх. 2.15. Гэрээ байгуулах үед авлига, ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн шалгуулах. Гурав. Үйлдвэрийн газрын захирал /дарга/-ын эрх, үүрэг дараах заалтуудыг тусгаж өгсөн. Үүнд: 3.31. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх. 3.32. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг журмын дагуу гаргаж, бүртгүүлэх. 3.33. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй үед хуульд заасан эрх мэдлээ хэрэгжүүлэхийг зөвшөөрөхгүй байх.</p>
--	--	--	---	--	--	--	---	---	---

							3.34. Гэрээ байгуулах үед авлига, ашиг сонирхлын шинжтэй зөрчил илэрсэн бол Авлигатай тэмцэх газар буюу холбогдох албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх. 3.35. Илт ашиг сонирхлын зөрчил үүссэн нөхцөлд албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх тус тус заалтуудыг тусгаж өсгөн.	
4	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	4.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх (үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, асуудлыг шийдвэрлүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх г.м)	Үйл ажиллагаанд эрсдэлийг тодорхойлж, урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг тооцсон байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	0	1	Хугацаа болоогүй	0	

			4.2. Салбарын хэмжээнд авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох, хүнд суртлыг бууруулах чиглэлээр хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулж, шалтгаан нөхцөлийг арилгасан байх.	Хоёроос доошгүйг зохион байгуулсан байх	0	2	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран 10 дугаар сарын 17-ны өдөр Орон нутгийн өмчит 40 байгууллагын ЭБАТ нарын дунд “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сургалт, өмчийн салбарт авлига, ашиг сонирхлын зөрчил гарч болзошгүй эрсдэл байгаа эсэхийг тодорхойлсон хэлэлцүүлгийг тус тус “Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох” сэдвийн хүрээнд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт оролцсон албан хаагчдаас гарсан санал, хүсэлтийг 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд хэрэгжүүлэн ажиллахаар боллоо. <b>Үр дүн:</b> ✓ Өмчийн салбарт авлигын эсрэг хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон	30
			4.3. Үйлчлүүлэгчдээс авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгаа авч, судалгааны дүгнэлтэд тулгуурлаж арга хэмжээ зохион байгуулах.	Бодитой үр дүнг тооцсон байх(Тайланд нотломжийг хавсаргасан байх)	0	1	Дундговь аймгийн ОНӨГ-ын Авлигын эрсдэл, үйл ажиллагааны хүндрэл бэрхшээлийг тодорхойлох сэтгэл ханамжийн судалгааг боловсруулан байгууллагаас үйлчилгээ авсан хувь хүн, иргэд, тус газраас зохион байгуулсан сургалт, хэлэлцүүлэгт оролцсон төрийн албан хаагчдаас судалгааг авч өөрийн байгууллагын үйл ажиллагааны бодит үр дүнг тооцон арган ажиллаж байна. Хууль эрх зүй орчиныг боловсронгуй болгох гэсэн санлын дагуу “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй эд хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-д нэмэлт	100

							Тус судалгааг өөрийн албан ёсны сайт, фейсбүүк пейж хуудсанд байршуулан олон нийтэд түгээсэн.	
5	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх.	5.1. Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, албан хаагчдад танилцуулан, үр дүнг тооцох	Төлөвлөгөөг баталж, танилцуулах арга хэмжээг зохион байгуулсан байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	0	1	2024 оны байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдөр газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус төлөвлөгөөг албан ёсоор баталгаажуулсны дараа албан хаагчдад заалт бүрээр танилцуулан хариуцах ажлыг нь тайлбарлан өгч ажиллалаа.	100	
			Албан хаагчдаас гаргасан санал санаачилгыг хэлэлцсэн байх (Тайланд нотломжийг хавсаргасан байх)	0	1			
		5.2. Төрийн албан хаагчдад шударга ёсыг төлөвшүүлэх зорилготой нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Khutulbur.iaac.mn цахим санд тайлагнасан байх	0	1		Хугацаа болоогүй	0
	Төлөвлөгөө, тайлантай олон нийтийг танилцуулах боломжоор хангасан байх.	0	1					

			5.3. АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газар пейж хуудсыг албан хаагчдаар дагуулах ажлыг зохион байгуулах.	Аян, хэлэлцүүлэг зэрэг үйл ажиллагаанд тус пейжийг сурталчилж, иргэд, төрийн албан хаагчдаар дагуулж, үр дүнг тооцсон байх (тийм-1, үгүй-0)	0	1	АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газрын пейж хуудсыг албан хаагчдаар дагуулах ажлыг зохион байгууллаа. Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг тодорхойлох сэдэвт Аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран зохион байгуулсан хэлэлцүүлэг, “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг идэвхжүүлэх сургалтад хамрагдсан нийт 80 албан хаагчдаар дээрх фейсбүүк пейж хуудаснуудыг дагуулж хэрэгжилтийг ханган ажиллалаа. <b>Үр дүн:</b> ✓ АТГ-Олон нийтийн төв, Авлигатай тэмцэх газрын пейж хуудасны гишүүдийн тоо нэмэгдсэн.	100
			5.4. Таван “Ш” ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллах	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	0	1	“Шүүр” ажиллагааны хүрээнд Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн албан хаагчид Төрийн албаны тухай хууль болон холбогдох дүрэм, журам, албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг ханган томилогдсон эсэхэд хяналт шалгалт хийж ажиллалаа. Хяналт шалгалтаар зөрчил илрээгүй болно. Тус байгууллагад Төрийн захиргааны 4 албан хаагч, үйлчилгээний 1албан хаагч ажиллаж байна. Тухайн 5 албан хаагч нь Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам, тогтоолын дагуу томилогдсон болно. Сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөл хүргүүлэн Дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтнийг шилжүүлэн авч томилсон.	100



						<p>“Шил” ажиллагааны хүрээнд Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар нэртэй цахим сайтыг ажиллуулж өөрийн байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлтэйгээр мэдээлэн ажиллаж байна. shilen.gov.mn сайтад ил тод мэдээллийн шалгуур үзүүлэлтийн дагуу байгууллагын үйл ажиллагааг ил тод тайлагнан хэрэгжилтийг ханган ажиллалаа. Хагас жилээр нээлтэй ил тод мэдээлэл 71%-тай үнлэгдсэн.</p> <p><b>Үр дүн:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ Шил ажиллагааны хүрээнд нээлтэй ил тод мэдээллийн үнэлгээ өмнөх оны үнэлгээнээс .. хувиар нэмэгдсэн.</li> </ul>	
Нийт дүн:							73.6%